



Олон улсад магтагдсан МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

“Summer school 2021” соёлын солилцооны хөтөлбөр амжилттай хэрэгжлээ

Индонез улсын Airlangga болон Мандах их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд “Summer school 2021” соёлын солилцооны хөтөлбөр амжилттай хэрэгжиж дууслаа. Индонез улсын Airlangga Их сургууль болон Мандах Их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд 2021 оны 9 сарын 25-с 10 сарын 6-ны хооронд соёлын солилцооны хөтөлбөрийг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Airlangga Их сургууль нь Индонезийн хамгийн эртний хоёр дахь их сургууль бөгөөд Зүүн Жава мужийн Сурабая хотод байрладаг олон нийтийн их сургууль юм. Уг хөтөлбөрт Airlangga Их сургуулийн 2-р дамжааны 15 оюутан, Мандах Их сургуулийн Нягтлан бодох бүртгэл-Англи хэлний ангийн 4-р дамжааны 15 оюутан тус тус хамрагдаж өөрийн улсын түүх, соёл, шашин шүтлэг, уламжлал, ёс жаяг, амьдралын хэв маягийг үндэсний бэлгэдэл, бүжиг, хэл, сургуулийн онцлог, давуу тал, сургалтын хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл солилцлоо. Хөтөлбөрийн төгсгөлд идэвхтэй байсан оюутнуудад Өргөмжлөл гардуулж, Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн зүгээс талархал илэрхийлэн, цаашдын хамтын ажиллагааг дэмжин ажиллахаа тодотгон, дараагийн үйл ажиллагааг буюу Winter event хөтөлбөрийг зохион байгуулахаар товллоо. Мөн цаашид хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж тухайн Их сургуулийн багш, оюутнуудыг эрдэм шинжилгээ хурал, аливаа зохион байгуулалттай үйл ажиллагаанд урьж оролцуулах төдийгүй мэргэжлийн зарим хичээлүүдийг багш солилцооны хэлбэрээр онлайн байдлаар заах зэрэг үйл ажиллагаагаа өргөжүүлж ажиллахаар урьдчилсан байдлаар тохиролцлоо.



Багш нарын баяраа цахимаар тэмдэглэлээ

Дэлхийн багш нарын 27, Монголын багш нарын 55 дахь өдрийн баярын арга хэмжээ 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр цахимаар зохион байгуулагдлаа. Уламжлал ёсоор 2020-2021 оны хичээлийн жилд сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан шилдэг багш нараа тодруулан шагнаж урамшууллаа. 2021 оны “Оны шилдэг багш”-аар Ахисан түвшний сургуулийн захирал, доктор (Ph.D), дэд профессор С.Цолмон, “Шилдэг залуу багш”-аар Эдийн засаг, бизнесийн тэнхмийн багш П.Насанжаргал нар шалгарч, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав. Мөн БШУЯамны “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр Бүртгэл шинжилгээний тэнхимийн доктор, дэд профессор А.Наранцэцэг, “Мэдээлэл харилцаа холбооны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр Мэдээлэл, технологийн сургуулийн захирал Ө.Ганзориг, Компьютерийн ухааны тэнхимийн ахлах багш Я.Сүхбаатар нар, МХИДСХолбооны “Шилдэг багш”-аар Бүртгэл шинжилгээний тэнхимийн багш Э.Энх-Амгалан, З.Ундармаа, Компьютерийн ухааны тэнхимийн багш Н.Ринчмаа нар тус тус шалгарлаа. Тус сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр дараах багш нарт “Ахлах багш”-ийн зэрэг олголоо. Үүнд:

Ш.Цэцэгжаргал	Бүртгэл шинжилгээний тэнхимийн багш
Ж.Нарантуяа	Суурь шинжлэх ухаан инженерчлэлийн тэнхимийн багш
Д.Энхбилэг	Дархан-уул аймаг дахь салбар сургуулийн багш
Э.Өлзийхишиг	Дархан-уул аймаг дахь салбар сургуулийн багш
Б.Оюунцэцэг	Дархан-уул аймаг дахь салбар сургуулийн багш

Сургуулиас 3 жил тутам олгодог онцгой шагнал болох Samsung Tab S7-ын эзнээр Эдийн засаг, бизнесийн тэнхимийн багш Ж.Гантулга шалгарсан бол Бүтээлч саналаа ажил хэрэгч төсөл болгон амжилттай хэрэгжүүлж, сургуулийн төлөвлөлт, тайлан гаргах ажлыг боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан Гадаад хэлний тэнхимийн эрхлэгч Б.Баатарцогтод төслийн санхүүжилтийг гардуулан өглөө. Арга хэмжээний үеэр их сургууль болон лицей сургуулийн шинэ багш, ажилтнууд урлагийн үзүүлбэрээр мэндчилгээ дэвшүүлээ.



Дотоод хамтын ажиллагаа

Мандах их сургууль болон Номин Холдинг ХХК-ны хооронд хамтран ажиллах гэрээ байгууллаа

Мандах их сургууль болон Номин Холдинг ХХК-ны хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, 2021 оны 10-р сарын 25-ны өдөр Мандах их сургуулийн Сургалт хариуцсан дэд захирал, Доктор (Ph.D), дэд Профессор Ч. Төрбадрах, Номин Холдинг ХХК-ны Хүний нөөцийн бодлогын газрын захирал Д. Отгонням нар гарын үсэг зурлаа. 2 тал Хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу оюутнуудын дадлагын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, суралцагсдыг цагийн болон үндсэн ажлын байраар хангах, шилдэг оюутнуудад зориулсан тусгай төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, ажилтнуудад боловсролын зэрэг олгох, зэрэг ахиулах, сургалт, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



Дотоод хамтын ажиллагаа

Мандах их сургууль Ай И Ди Си Олон улсын боловсрол төвтэй Пирсон Академик англи хэлний хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх тухай гэрээ байгууллаа

Мандах Их Сургууль Ай И Ди Си Олон улсын боловсролын төвтэй Пирсон Академик англи хэлний хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх тухай гэрээнд гарын үсэг зурах үйл ажиллагаа 2021 оны 10-р сарын 27-ны өдөр Мандах их сургуулийн уулзалтын танхимд боллоо. Гэрээнд Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, Доктор Ph.D, дэд профессор Ч. Төрбадрах, Ай И Ди Си байгууллагын захирал М. Найдалмаа нар гарын үсэг зурлаа. Мандах их сургууль тус боловсролын байгууллагатай өмнө нь байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд багш нарынхаа англи хэлний чадавхийг дээшлүүлэх, TEFL болон TESOL хөтөлбөр, Грийнвичийн их сургуулийн (ИБУИНВУ) итгэмжилсэн Мэргэжлийн Англи хэлний олон улсын хөтөлбөр, бизнесийн удирдлага, маркетинг, олон нийтийн харилцааны чиглэлээр мэргэшүүлэх хөтөлбөрийг амжилттай хамтран хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд Мандах их сургуулийн англи хэлний багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулснаас Гадаад хэлний тэнхимийн 4 багш Лондон хотын Багш сургалтын коллежийн 180 цагийн хичээлийг судлан, Англи хэлийг бүх түвшинд заах эрх бүхий дипломыг өнөөдөр гардан авлаа. Энэ удаагийн хамтран ажиллах гэрээний зорилго нь олон улсын стандартад нийцсэн PEARSON-EAP хөтөлбөрийг Мандах их сургуулийн англи хэлний багш нарын нөөц бололцоонд тулгуурлан, цогц цахим систем бүхий багц сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оршино.



Мандах их сургууль болон “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ны хооронд хамтран ажиллах гэрээ байгууллаа

Мандах их сургууль болон “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ны хооронд хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, 2021 оны 12-р сарын 03-ны өдөр Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, Доктор (Ph.D), дэд Профессор Ч. Төрбадрах, “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ны Захиргаа, Хүний нөөцийн албаны захирал Г. Сарангэрэл нар гарын үсэг зурлаа. Хоёр тал хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны дагуу оюутнуудын дадлагын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, суралцагсдыг цагийн болон үндсэн ажлын байраар хангах, шилдэг оюутнуудад зориулсан тусгай төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, ажилтнуудад боловсролын зэрэг олгох, зэрэг ахиулах сургалт дамжаа зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо.



Шагнал урамшуулал

“Ээлтэй байгууллага 2021”-р тодров

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр (12 дугаар сарын 03)-ийг угтан “БЭРХ БИШ ЭЭЛТЭЙ” аяныг 2021 оны 10 дугаар сараас эхлүүлсэн ба аяны хүрээнд мультимедиа контент, нийтлэлүүд, чөлөөт уран бүтээлчдийн бүтээл, “Бэрх биш ээлтэй” хөдөлмөрийн экспо, “Манай байгууллага ээлтэй” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Дээрх аяны хүрээнд Мандах Их Сургуулийг “Ээлтэй байгууллага 2021”-ээр тодруулж, Талархлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Б.Тамир 2021 оны 11 дүгээр сарын 23-нд гардуулан өглөө. Тус сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих хөтөлбөртэйгээс гадна налуу зам, цахилгаан шат, давхар бүрт ариун цэврийн өрөө бүхий хичээлийн байртай болно.



Татварын бүртгэл - 2021 улсын VIII олимпиадад Мандах Их Сургуулийн багш, оюутнууд амжилттай оролцлоо.

Татварын бүртгэлийн олимпиадын зорилго нь оролцогчдын татвар, санхүү, нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг ур чадварыг сорих, мэргэжлийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, заавар стандартын талаарх мэдлэгийг дээшлүүлж, хэрэглээ болгон идэвхжүүлэхэд оршино. Тус олимпиадын хамрах хүрээ нь Бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулийн оюутан, Нягтлан бодогч, татварын улсын байцаагч гэсэн 2 ангиллаар явагдлаа.



Олимпиад 2 үе шаттай бөгөөд 1-р үе шат: 2021.10.20-ны өдөр цахимаар, 2-р үе шат: 2021.10.29-ний өдөр Мандах Их Сургуулийн байранд танхимаар болж өндөрлөлөө. Нягтлан бодогч, татварын улсын байцаагчийн ангилалд Мандах Их Сургуулийн Бүртгэл шинжилгээний тэнхимийн ахлах багш М.Энхсүрэн Тэргүүн байр, багш Б.Ганбагана Гутгаар байрт шалгарлаа.

Тэмцээн уралдаан

Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б.Сандагсүрэнгийн нэрэмжит 4 төрөлт спорт тэмцээн амжилттай боллоо.

Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б. Сандагсүрэнгийн нэрэмжит сургуулийн аварга шалгаруулах уламжлалт спорт тэмцээн 2021 оны 11 сарын 9-19-ны өдөр хүртэл амжилттай болж өндөрлөлөө. Сургуулийн аварга шалгаруулах энэхүү тэмцээнийг 1997 оноос хойш уламжлал болгон зохион байгуулж ирсэн бөгөөд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4 төрөлт тэмцээн болон өргөжиж, тамирчдын чансаа ч улам сайжирч байна.

Ширээний теннис:

Эмэгтэй төрөл:

Тэргүүн байр: Ц.Цэрэнчимэд НББ-Аудит 4

Дэд байр: Б.Золгэрэл Бизнесийн Удирдлага-1

Гуравдугаар байр: Н.Хулан Банкны Менежмент-1

Эрэгтэй төрөл:

Тэргүүн байр: Н.Занданхүү Банкны Менежмент-2

Дэд байр: П.Төгөлдөр Мэдээллийн Систем-1

Гуравдугаар байр: Х.Түвшинтулга Бизнесийн Удирдлага-1

2018 онд 32 баг оролцож байсан бол энэ жилийн тэмцээнд нийт 49 баг тамирчид хоёр долоо хоногийн турш өрсөлдөж өнөөдөр нэгдсэн дүнгээ гаргаж, аваргуудаа тодрууллаа. Үүнд:

Шатар:

Эрэгтэй төрөл:

Тэргүүн байр: С.Батсүх Санхүүгийн Менежмент-1

Дэд байр: Э.Төгөлдөр НББ-Банк 2

Гуравдугаар байр: Г.Ган-Эрдэнэ Программ Хангамж-4

Эмэгтэй төрөл:

Тэргүүн байр: А.Үүрийнцолмон НББ англи хэл-4

Дэд байр: М.Зандрагчаа Мэдээллийн Систем-1

Гуравдугаар байр: Л.Маралмаа НББ-Аудит 2

Сагсан бөмбөг:

Эрэгтэй төрөл:

Тэргүүн байр: Санхүү менежмент-4

Дэд байр: Логистик менежмент-1

Гуравдугаар байр: Программ Хангамж-4

Эмэгтэй төрөл:

Тэргүүн байр: НББ-Татвар 2

Дэд байр: НББ-Статистик 4

Гуравдугаар байр: НББ-Аудит 2

Гар бөмбөг:

Эмэгтэй төрөл:

Тэргүүн байр: НББ-Аудит хөтөлбөр

Дэд байр: НББ-Татвар хөтөлбөр

Гуравдугаар байр: НББ-Мэдээллийн систем хөтөлбөр

Эрэгтэй төрөл:

Тэргүүн байр: НББ-Банк хөтөлбөр

Дэд байр: НББ-Татвар хөтөлбөр

Гуравдугаар байр: Санхүү менежмент хөтөлбөр



Олон улсын тэмцээнд амжилттай оролцлоо

ACBSP-ийн гишүүн орнуудын бизнес, эдийн засгийн сургуулийн оюутан, суралцагчдын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг бизнес кейс тэмцээнийг Энэтхэгийн Шинэ Дели хотод байрлах Перегрин Глобал Сервис байгууллагын түнш SEAA Trust байгууллага 5 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан бөгөөд уг тэмцээнд Мандах их сургууль анх удаа оролцлоо. Уг тэмцээн 2021 оны 9-р сарын 15-с 11-р сарын 27-ны хооронд 3 н үе шаттайгаар, цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. Тэмцээний 1-р шатанд дараахи сэдвүүдээр 2500 үгтэй эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулагдсанаас 70 гаруй сургуулийн баг 2-р шатанд шалгарч үлдсэн.

Teaching technology for non- technology students

Building an attitude for life long learning

Ease of use of digital learning strategies and tools

External digital expert involvement in teaching and learning

Learning from Global MBA experience in Digital era)

2-р шатанд багууд Перегрин Глобал Сервисийн Business School Resource center-ээс сонгогдсон кейсийн дагуу асуудлыг шийдвэрлэн 15 минутын хугацаатай илтгэлийг видео хэлбэрээр бэлтгэж оролцсон бөгөөд шилдэг 12 илтгэлийг шалгаруулсанаас Мандах их сургуулийн баг мөн амжилттай оролцож 3-р шатанд оролцох болзлыг хангасан.

3-р шатанд шилдэг 12 багийн хүрээнд кейсийн дагуу танилцуулга хийж, асуултанд хариулах байдлаар цахим хурал явагдаж шилдэг илтгэл бүхий багуудыг шалгаруулсан бөгөөд 3-н тэмцээний нийлбэр оноогоор:

1-р байранд Отгонтэнгэр Их Сургууль

2-р байранд Kettering University, АНУ

3-р байранд Мандах Их Сургууль тус тус эхний 3-н байрыг эзэллээ.

Мандах Их Сургуулийг төлөөлөн оролцсон Санхүү менежментийн хөтөлбөрийн 4-р дамжааны оюутан Х.Гүлнур, Нягтлан бодох бүртгэл-статистикийн хөтөлбөрийн 4-р дамжааны оюутан Г.Энхжин, Нягтлан бодох бүртгэл- англи хэлний хөтөлбөрийн 4-р дамжааны оюутан Б.Очирхуяг болон багаа удирдан оролцсон.



Уралдаан тэмцээн

“Бизнесийн англи хэл-2021” тэмцээн зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн ГХТ-ээс “BUSINESS ENGLISH-2021” тэмцээнийг 2021 оны 11 сарын 8-9-ний өдрүүдэд НББАудит, НББТатвар, НБББанк, НББАнгли хэл, Санхүүгийн Менежмент, Банкны Менежмент, Логистик Менежмент, Инженер Эдийн Засаг мэргэжлийн 3-р курсын 8 ангийн оюутнуудын дунд найм дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Оюутнууд ганцаарчилсан болон багийн хэлбэрээр нийт 5 даалгавар гүйцэтгэж, тэмцээний төрөл тус бүрээр эхний 3 байрт шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа. Үүнд:

Бизнесийн захидал бичих /Ганцаарчилсан/

- 1 байр-Одонбаярын Эрхэс /БМ/
- 2 байр-Анхбаярын Эрдэнэболд /ИЭЗ/
- 3 байр-Цогтгэрэлийн Энхзаяа /НББТатвар/

Сонсох чадвар шалгах /Ганцаарчилсан/

- 1 байр-Ганбаярын Анхбаяр /СМ/
- 2 байр-Болормаагийн Тэмүүлэн /ЛМ/
- 3 байр-Байгалийн Ичинхорлоо/ИЭЗ/

АХА /Ганцаарчилсан/

- 1 байр-Нямбаярын Уянга /НББТатвар/
- 2 байр-Эрдэнэчулууны Зол-Учрал /НББАнгли хэл/
- 3 байр-Мөнхбатын Батцэцэг /НББАудит/

График тайлбарлах /Багийн/

- 1 байр-НББ Англи хэл анги
- 2 байр-НББ Татвар анги
- 3 байр-НББ Аудит анги

Харилцагчийн үйлчилгээ /Багийн/

- 1 байр- НББТатвар анги
- 2 байр- НББАнгли хэл анги
- 3 байр-ЛМ, ИЭЗ анги



Ажлын байрны нээлттэй өдөрлөг-2021 зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Маркетингийн комисстой хамтран төгсөгч болон 3,4-р курсын оюутнуудыг дадлагын болон байнгын ажлын байранд зуучлах, хамтран ажиллагч байгууллагуудын хүний нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ажлын байрны нээлттэй өдөрлөг”-ийг жил бүрийн 12 сард зохион байгуулдаг. Энэ хичээлийн жилийн “Ажлын байрны нээлттэй өдөрлөг”-ийн арга хэмжээ 2021 оны 12 сарын 7,8-ны өдрүүдэд боллоо.



Өдөрлөгийн үеэр ажил олгогчдийн төлөөлөлтэй уулзаж, оюутан болон төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагын талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан нь бидний цаашдын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийг сайжруулахад ач холбогдол өгсөн уулзалт боллоо.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалтын эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

З.Булганаа / Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Номын санч /
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn